



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/32

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1 /а/, Сангийн сайдын 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгуудын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнд оролцож буй “Эрдэнэт-Икон” багийн Орхон аймаг дахь тоглолтын зардал болон аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд шаардагдах жижиг эд хогшил авах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Уг зардалд шаардагдах 2751300 /Хоёр сая долоон зуун тавин нэгэн мянга гурван зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ